



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 23 өдөр

Дугаар 1/305

Хэрлэн сум

Ногоочдын зөвлөгөөн зохион  
байгуулахад хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 2 дугаар хуралдааны "Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" 06 дугаар, 2023 оны 18 дугаар хуралдааны "Аймгийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай" 2 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Ногоочдын зөвлөгөөн 2023" арга хэмжээг зохион байгуулахад зориулж 2,580,900 (хоёр сая таван зуун наян мянга есөн зуу) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, ажлын гүйцэтгэлийг хянаж шалгах, үр дүнг танилцуулж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (Ж.Энх-Амгалан)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Э. Мөнх-Эрдэнэ)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

05  
 Д/305  
 Аймгийн Засаг даргын 2023 оны  
 дугаар сарын 23-ны өдрийн  
 дугаар захирамжийн хавсралт

ХЭНТИЙ АЙМГИЙН ТАРИАЛАНЧДЫН ЗӨВЛӨГӨӨНИЙ ТӨСӨВ

№	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ	Үүнээс	
						ЗДТГ	Хөгжлийн шийдэлТББ мэдээ мэдээлэл
1	Үдийн цай	х/тоо	55	11000	605000		440000
2	Заалны түрээс	цаг	7	30000	210000		
3	Сургалтын хэрэгсэл	х/тоо	55	25000	1375000		
4	Оройн цай	х/тоо	55	7110	390900		
НИЙТ ДҮН:					2580900	2580900	440000